

**Өлгий сумын ЗДТГ-ын 05-р сарын 03-с эхлэн 7 хоногт  
хийсэн ажлын мэдээлэл**

**2019-05-09**

- 9-р багийн нутаг дэвсгэрт байгаа оршуулгын газрыг сумын ОНХСангийн хөрөнгөөр хашаажуулах ажлын газар сонголтын хийв.
- 5,11-р багуудад шинээр тавигдах авто замын улаан шугамд орсон айл өрхүүдэд газар чөлөөлөх хугацаатай мэдэгдэх хуудас өгч ажиллаж байна.
- Өлгий сумын ОНХСангийн 2019 оны хөрөнгөөр шинээр барих 2-р багт барьж байгуулах тоглоомын талбайн газар сонголтыг хийж зургийг үйлдэж өгөв.
- Аймгийн ЗДТГазраас зохион байгуулж буй “Эрүүл хүнс” сарын аяны хүрээнд Өлгий сумын 12 багийг 5 чиглэлд хуваарилан холбогдох мэргэжлийн байгууллагын хүмүүстэй хамтран хяналт шалгалтын ажил хийгдэж байна.
- Аймгийн МХГазраас ирүүлсэн албан бичгийн дагуу хэрэглэх хугацаан хэтэрсэн 333ш нийт 756000 мянган төгрөгийн үнэ бүхий хураагдсан шар айргийг зохих журмын дагуу устгал хийхээр ажлын хэсэг шийдвэрлэсэн болно.
- Дулааны цаг улирал эхэлж байгаад тул Өлгий сумын “А” бүс засмал замын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага худалдаа үйлчилгээний цэг салбаруудад цаашид тохижилтын ажил хийх талаар “Мэдэгдэх хуудас” хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаж байна.
- ЗДТГазрын төрийн албан хаагч нарын төрийн албаны тухай хуулийн шинэчлэн найруулагдсантай хобогдуулан ажил байдлын тордорхойлолтыг боловсруулав.
- “Тэнгэр-Алтан тосго” ХХК-тай гэрээ байгуулж түгээмэл тархацтай ашигт малтмалын үнэ төрийн сан банканд 1200000 мянган төгрөгийн хураамж оруулав.
- Аймгийн МХГазраас гаргасан удирдамжийн дагуу Ховд голын эрэгт 2 удаа хуваарийн дагуу шөнийн цагаар эргүүлд гарч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар бусад байгууллагуудад хамтран ажиллав.
- Орон нутгийн телевизээр байгаль орчны тухай болон зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар ард иргэдэд ухуулгаа сурталчилгаа хийв.
- Гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж бтн хог ачиж хогийн цэгт хүргэв.
- Гудамж зам талбайг шөнийн гэрэлтүүлгээр хангаж, төв талбайн гэрэлтүүлгийн урсгал засваруудыг хийж шөнийн гэрэлтүүлгээр хангаж байна.
- СӨХ-ны хогийг ачиж орон сууц орчмын цэвэрлэгээ хийж, хог шатаах явдалд хяналт тавьж ажиллаж байна
- Цэцэг тарих ажлын бэлтгэл ажлыг эхэлж цэцгийн мандлуудын шороог цэвэрлэж шарилжуудыг нь авч шороог услан цэцэг тарих ажлын бэлтгэл ажил хийж байна.
- Цэнгэлдэх хүрээлэнгийн талбайг услах ажил хийж байна.
- Ногоон бүсийн хашаануудыг усалж эхлэв.

**ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ**